



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/759

Булган сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын тамгын газар (РД:9012419)-т Булган сумын 1 дүгээр баг Л.Энэбиш 2 дугаар гудамж 202 тоотод байршилтай 4327321 төлөвлөлтийн дугаартай 37670 м2 газрыг нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлж, зүлэгжүүлсэн талбай зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Эрдэнэбилэг)-тай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг Аймгийн Засаг даргын тамгын газарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР